

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МӨСТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/34/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Гэрээт аудитор: Д.Нарантуул Утас: 70432545 цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ТБОНӨХБАҮХАТ</i>	<i>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<i>ИТХ</i>	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/	6
2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/	7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
/төгрөгөөр/.....	9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/	9
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН	10
3.АУДИТЫН ТАЙЛАН	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт	15
Залруулсан алдаа:Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	15
Аудитын зөвлөмж:	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
Аудитаар материаллаг хэмжээний алдаа зөрчил илэрсэн тул тус байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалтай дүгнэлт өгч, ТТЗ-ын тайлангаар сахилгын шийтгэл ноогдуулах асуудлыг авч үзэх шаардлагатай.....	
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	17

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

МӨСТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Т.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

2021-02-25 № 2/99
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мөст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургуулийн өмнөх боловсролын чанарын үр дүн, хэрэгжилт, багшийн ёс зүйн байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлан дахь тоо мэдээлэл нь үнэн эсэх нь тодорхой бус, авлага тусгаагүй, хүнсний болон түлээ нүүрсний худалдан авалт зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, Шилэн дансны хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтуудыг мөрдөөгүй, аудитын "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

001020574

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,165,591.10</u>	<u>11,820,191.10</u>
33	АВЛАГА	2,899,000	2,634,900
335	Бусад авлага	1,725,000	2,634,900
3351	Байгууллагаас авах авлага	1,725,000	2,163,900
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	471,000
34	УРЬДЧИЛГАА	1,499,050	300,000
3471	Урьдчилгаа тооцоо	1,499,050	300,000
34713	Цалингийн урьдчилгаа	1,499,050	300,000
35	БАРАА МАТЕРИАЛ	13,767,541.10	8,885,291.10
354	Хангамжийн материал	13,767,541.10	8,885,291.10
35420	Аж ахуйн материал	113,000	635,750
35440	Түлш, шатах тослох материал	1,337,000	1,198,300
35460	Хүнсний материал	5,516,141.10	2,735,041.10
35470	Бусад хангамжийн материал	6,801,400	4,316,200
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,096,769,485.86</u>	<u>1,086,106,349.79</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,096,769,485.86	1,086,106,349.79
392	Биет хөрөнгө	1,091,052,769.86	1,080,401,051.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,079,389,617.80	1,079,389,617.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(93,095,646.01)	(101,848,239.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	204,855,450	203,040,250
39206	Хуримтлагдсан элэгдэл	(116,178,678.93)	(115,425,061.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,247,208	42,651,708
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,779,081)	(30,021,123.13)
39217	Ном	2,613,900	2,613,900
393	Биет бус хөрөнгө	5,716,716	5,705,298.09
39301	Программ хангамж	1,006,716	1,006,716
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000)	(561,417.91)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,260,000	5,260,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,114,935,076.96</u>	<u>1,097,926,540.89</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,671,570.00</u>	<u>2,717,932.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,671,570	2,717,932
413	Өглөг	1,671,570	2,717,932
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	139,662
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	132,050
4136	Бусад өглөг	1,671,570	2,446,220
41361	Байгууллагад төлөх өглөг	320,000	750,250
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,351,570	1,695,970
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,113,263,506.96</u>	<u>1,095,208,608.89</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,113,263,506.96	1,095,208,608.89

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	50,306,835	50,306,835
51101	Өмч: - төрийн	50,306,835	50,306,835
512	Хуримтлагдсан үр дүн	583,825,086.13	565,770,188.06
51210	Өмнөх үеийн үр дүн	583,825,086.13	579,334,501.13
51220	Тайлант үеийн үр дүн	-	(13,564,313.07)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	479,131,585.83	479,131,585.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,114,935,076.96</u>	<u>1,097,926,540.89</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	288,196,038	302,379,200
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,291,238	4,249,400
120	Нийтлэг татварын бус орлого	2,291,238	4,249,400
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,291,238	4,249,400
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	750,400
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,291,238	3,499,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	285,904,800	298,129,800
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	268,868,100	281,234,600
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	268,868,100	281,234,600
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,036,700	16,895,200
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,036,700	16,895,200
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	340,790,262.82	315,910,333.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	340,790,262.82	315,910,333.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,916,662.82	283,316,285.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,216,370	197,527,284.37
210101	Үндсэн цалин	182,216,370	131,633,829.22
210102	Нэмэгдэл	-	54,514,260.15
210104	Урамшуулал	-	11,379,195
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,911,925.94	24,394,580.26
210201	Тэтгэврийн даатгал	16,053,792.90	16,560,869.54
210202	Тэтгэмжийн даатгал	1,714,533.26	1,958,427.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,371,626.61	1,566,742.15
210204	Ажилгүйдлийн даатгал	342,906.65	391,685.53
210205	Эрүүл мэндийн даатгал	3,429,066.52	3,916,855.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,001,026	13,886,505.40
210301	Гэрэл, цахилгаан	2,480,196	2,277,855
210302	Түлш, халаалт	11,317,500	11,368,650.40
210303	Цэвэр, бохир ус	3,203,330	240,000
2104	Хангамж, бараа материалын зардал	4,532,529	8,230,409.60
210401	Бичиг хэрэг	255,986	166,600
210402	Тээвэр, шатахуун	349,043	2,351,109.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000	56,000

210404	Ном, хэвлэл	62,000	10,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,765,500	5,646,700
2105	Нормативт зардал	41,032,778.90	24,645,750
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,561,900
210502	Хоол, хүнс	40,789,678.90	23,083,850
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	243,100	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	136,100	-
210604	Урсгал засвар	136,100	-
2107	Томилолт, зочны зардал	80,920	-
210702	Дотоод албан томилолт	80,920	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	252,800
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	52,800
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	200,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,005,012.98	14,378,956.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	241,800	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	250,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,763,212.98	14,128,956.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,873,600	32,594,047.37
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,873,600	31,843,647.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,873,600	31,843,647.37
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	750,400
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	750,400
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(52,594,224.82)	(13,531,133.15)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	33,179.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	33,179.92
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(33,179.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(52,594,224.82)	(13,564,313.07)

2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	285,904,800	298,880,200
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	750,400
120	Нийтлэг татварын бус орлого	-	750,400
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	750,400
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	750,400
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	285,904,800	298,129,800
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	268,868,100	281,234,600
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	268,868,100	281,234,600
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,036,700	16,895,200
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,036,700	16,895,200
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	285,904,800	298,880,200
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285,904,800	298,880,200

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271,031,200	266,286,153
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,005,047	195,842,768
210101	Үндсэн цалин	121,171,928	129,949,313
210102	Нэмэгдэл	42,718,219	54,514,260
210104	Урамшуулал	2,626,159	11,379,195
210105	Гэрээт ажлын хөлс	13,488,741	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,440,900	24,221,970
210201	Тэтгэврийн даатгал	17,845,700	15,128,970
210202	Тэтгэмжийн даатгал	2,062,700	2,273,400
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,756,000	1,818,700
210204	Ажилгүйдлийн даатгал	285,200	454,500
210205	Эрүүл мэндийн даатгал	4,491,300	4,546,400
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,364,253	16,290,105
210301	Гэрэл, цахилгаан	2,480,196	2,610,805
210302	Түлш, халаалт	13,251,500	13,279,300
210303	Цэвэр, бохир ус	632,557	400,000
2104	Хангамж, бараа материалын зардал	872,900	1,191,500
210401	Бичиг хэрэг	78,100	78,100
210402	Тээвэр, шатахуун	545,700	862,300
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000	64,200
210404	Ном, хэвлэл	74,500	44,600
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	74,600	142,300
2105	Нормативт зардал	42,316,480	25,158,150
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,148,900
210502	Хоол, хүнс	42,041,980	22,613,050
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	274,500	396,200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,535,770	-
210604	Урсгал засвар	2,535,770	-
2107	Томилолт, зочны зардал	80,920	-
210702	Дотоод албан томилолт	80,920	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	182,500	312,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	182,500	112,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	200,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,232,430	3,269,660
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,397,450	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	834,980	3,269,660
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,873,600	32,594,047
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,873,600	31,843,647
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,873,600	31,843,647
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	750,400
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	750,400

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,306,835	479,131,585.83	583,825,086.13	1,113,263,506.96
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,306,835	479,131,585.83	583,825,086.13	1,113,263,506.96
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,306,835	479,131,585.83	583,825,086.13	1,113,263,506.96
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	50,306,835	479,131,585.83	583,825,086.13	1,113,263,506.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(4,490,585)	(4,490,585)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,306,835	479,131,585.83	579,334,501.13	1,108,772,921.96
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(13,564,313.07)	(13,564,313.07)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,306,835	479,131,585.83	565,770,188.06	1,095,208,608.89

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	285,904,800	271,031,200	298,129,800	266,286,152.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285,904,800	271,031,200	298,129,800	266,286,152.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,904,800	271,031,200	298,129,800	266,286,152.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,479,300	180,005,047	218,860,900	195,842,768
210101	Үндсэн цалин	123,574,200	121,171,928	141,620,800	129,949,312.85
210102	Нэмэгдэл	52,730,500	42,718,219	63,167,100	54,514,260.15
210104	Урамшуулал	6,498,000	2,626,159	14,073,000	11,379,195
210105	Гэрээт ажлын хөлс	11,676,600	13,488,741		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,784,800	26,440,900	29,546,300	24,221,969.63
210201	Тэтгэврийн даатгал	17,533,700	17,845,700	20,791,700	15,128,969.63
210202	Тэтгэмжийн даатгал	2,062,700	2,062,700	2,188,800	2,273,400
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,650,200	1,756,000	1,750,900	1,818,700
210204	Ажилгүйдлийн даатгал	412,500	285,200	437,700	454,500
210205	Эрүүл мэндийн даатгал	4,125,700	4,491,300	4,377,200	4,546,400
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,913,700	16,364,253	16,796,800	16,290,105
210301	Гэрэл, цахилгаан	2,886,600	2,480,196	3,117,500	2,610,805
210302	Түлш, халаалт	13,627,100	13,251,500	13,279,300	13,279,300
210303	Цэвэр, бохир ус	400,000	632,557	400,000	400,000
2104	Хангамж, бараа материалын зардал	1,023,500	872,900	1,191,500	1,191,500
210401	Бичиг хэрэг	78,100	78,100	78,100	78,100

210402	Тээвэр, шатахуун	694,300	545,700	862,300	862,300
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	64,200	100,000	64,200	64,200
210404	Ном, хэвлэл	44,600	74,500	44,600	44,600
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142,300	74,600	142,300	142,300
2105	Нормативт зардал	42,480,100	42,316,480	27,426,600	25,158,150
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,900	-	2,148,900	2,148,900
210502	Хоол, хүнс	42,042,000	42,041,980	24,881,500	22,613,050
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,200	274,500	396,200	396,200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	123,000	2,535,770	98,400	-
210604	Урсгал засвар	123,000	2,535,770	98,400	-
2107	Томилолт, зочны зардал	80,900	80,920	80,900	-
210702	Дотоод албан томилолт	80,900	80,920	80,900	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,800	182,500	343,600	312,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,800	182,500	143,600	112,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-	200,000	200,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,910,700	2,232,430	3,784,800	3,269,660
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,129,600	1,397,450		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	781,100	834,980	3,784,800	3,269,660
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285,904,800	271,031,200	298,129,800	266,286,152.63
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	268,868,100	253,994,500	281,234,600	249,390,952.63
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	268,868,100	253,994,500	281,234,600	249,390,952.63
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,036,700	17,036,700	16,895,200	16,895,200
132001	Орон нутгийн төсвөөс	17,036,700	17,036,700	16,895,200	16,895,200
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	18	18	17
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	9	9
620003	Үйлчлэх ажилтан	5	5	5	4
620004	Гэрээт ажилтан	3	3	3	3

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	750,400
21	УРСГАЛ ЗАРДАЛ	750,400
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	750,400

213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	750,400
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	750,400
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	750,400
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	750,400

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Мөст сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Т.Оюунцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн программд холбогдох дансны бичилтийг үнэн зөв илэрхийлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мөст сумын цэцэрлэг нь “хүүхдүүдийг хөгжүүлэх, төлөвшүүлэх, сургалтын ээлтэй орчныг бүрдүүлж сургалтын чанарыг сайжруулан эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, багш ажилчдын ёс зүйг эрхэмлэнэ” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Мөст сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох
- хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох;
- хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах;
- хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Мөст сумын Цэцэрлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 оны санхүүгийн баримтад дотоод хяналт хийгдээгүй байна. Сумын санхүүгийн албанаас дотоод аудитын нэгжтэй боловч хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан ирүүлээгүй болно.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 340790.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3407.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 302409.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3024.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мөст сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17008.5 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	4,398.1	2,934.9	(1,463.2)
Бараа материал	13,767.5	8,885.3	(4,882.2)
Үндсэн хөрөнгө	1,096,769.4	1,086,106.3	(10,663.1)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,114,935.0	1,097,926.5	(17,008.5)
Богино хугацаат өр төлбөр	1,671.5	2,717.9	1,046.4
Цэвэр хөрөнгө, өмч	1,113,263.5	1,095,208.6	(18,054.9)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,114,935.0	1,097,926.5	(17,008.5)

Авлага дансны үлдэгдэл 2934.9 мянган төгрөг болж 1463.2 мянган төгрөгөөр буурсан шалтгаан нь материалын үнэ илүү шилжүүлсэн, ажилчдад худалдсан материалын үнэ суутган авахтай холбоотой барагдах боломжтой байна. Тайлан олон өмнөх онд цалингийн урьдчилгаа олгоод суутган аваагүйтэй холбоотой тооцоог авлагаар бүртгээгүйгээс төлбөрийн акт бичигдсэн болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 8885.3 мянган төгрөг болж 4882.2 мянган төгрөгөөр буурсан нь сумын ИТХ-ын тогтоолоор бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийг акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1336372.9 мянган төгрөг, оны эцэст 1333962.2 мянган төгрөг болж 2410.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 3499.0 мянган төгрөгөөр зөөврийн компьютер хандиваар авч нэмэгдсэн байна.

Өр төлбөр оны эхэнд 1671.5 мянган төгрөг оны эцэст 2717.9 мянган төгрөг болж 1046.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1094908.6 мянган төгрөг болж 18354.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх үеийн үр дүн данс руу 4790.6 мянган төгрөгийн залруулах бичилт хийгдсэн, тайлант онд 13564.3 мянган төгрөгийн ашигтай гарсан зэргээс шалтгаалж байна.

Мөст сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 14183.2 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 14183.2 мянган төгрөгийн орлогоос 12225.0 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, үнэ төлбөргүй орлого 1958.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 24874.9 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 16798.6 мянган төгрөг буюу 14.9 хувиар, хангамж бараа материалын зардал 3697.9 мянган төгрөг буюу 81.6 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 252.8 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 17720.4 мянган төгрөгөөр буюу 114.1 хувиар тус тус өссөн, буурсан, тогтмол зардал 3114.5 мянган төгрөг буюу 18.3 хувиар, норматив зардал 16387.0 мянган төгрөг буюу 39.9 хувиар, эд хогшил авах зардал 136.1 мянган төгрөгөөр, томилолтын зардал 80.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардал 43626.1 мянган төгрөг буюу 75.2 хувиар дээрх зардлууд буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн, ковид- 19 цар тахалтай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 372692.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 372692.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 281234.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 16895.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 298129.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 281234.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 16895.2 санхүүжилт авч, нийт 298129.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 266286.2 мянган төгрөгийг зарцуулж 31843.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 266286.2 мянган төгрөг буюу 89.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 16995.8, тогтмол зардал 506.7, нормативт зардал 2268.4, эд хогшил, урсгал засварын зардал 89.4, томилолтын зардал 80.9, бараа үйлчилгээний зардал 515.1, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 31.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээ 31843.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэл, халаалтын зардал, хоол хүнс арга хэмжээний зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,023.5
80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	605.1
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	2,268.4
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	620.1
81833	Явуулын багшийн үйлчилгээ	205.7
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	23,120.9
ДҮН		31,843.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар багш ажилчдаас суутгасан махны үнийг 100161815201 тоот данснаас 750.4 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулаагүй, оны эцэст сумын ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 135 мэдээллээс хугацаандаа оруулсан 129 мэдээллийг оруулсан, 9 хугацаа хоцроосон мэдээлэл, 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллийг хянахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын мэдээллийг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, сар бүрийн төсвийн хэмнэлт хэтрэлтийн тайлбар болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6195.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 11183.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлсэн, 6345.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг төлж барагдуулаагүй, 7207.1 мянган төгрөгийн

албан шаардлага, аудитаар өгсөн 218660.2 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	12,540.6	-	6,195.6	1	6,345.0	49.4
Албан шаардлага	1	18,390.3		11,183.20	1	7,207.1	60.8
Зөвлөмж	2	218,660.2			2	218,660.2	-
Нийт дүн	4	249,591.1	-	17,378.8	4	232,212.3	36.7

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 41691.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6787.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 7093.3 мянган төгрөгийн төлбөрийн акт бичиж, 25576.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа: Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Баш ажилчдад олгосон махны үнэ, оны эцэст нэмэлт данснаас татан төвлөрүүлсэн мөнгийг авлагаар 1221.4 мянган төгрөгийг бүртгээгүй,
2. Мо Эн Ко ХХК-д өмнөх оны 2100.0 мянган төгрөгийн нүүрсний өглөгийг тусгаагүй тайланд төлсөн ч зардлаар бүртгээгүй,
3. Хүнсний материалаас 1812.6 мянган төгрөгийн материалыг худалдан борлуулсан буюу акталж устгасан боловч хоолны зардлаар тайлагнасан,
4. Санхүүгийн программд бараа материалын орлого 2234.6 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн,
5. Тайлант үеийн үр дүнг 1653.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг аудитын явцад залруулга хийгдлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 9022.1 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 32669.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 7093.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 25576.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Өмнөх оны авлагыг барагдуулаагүй тайлант оны санхүүгийн тайланд өмнөх үр данс руу залруулга хийж хаасан, цалингийн урьдчилгаа олгоод суутган аваагүй, авлагаар тусгаагүй зардлаар тайлагнасан, аж ахуйн нэгж байгууллагад материалын үнэ илүү шилжүүлсэн тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнөх аудитаар тавигдсан төлбөрийн актыг төсвөөс төлсөн зэрэг нийт 7093.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Эрх ба үүрэг, Оршин байх, Тохиолдсон байх, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоож, хавсралтад заасан хүмүүс болон аж ахуйн нэгж байгууллагаар төлүүлэх.

2. Тайлант онд мах нийлүүлэх, хүнсний материал худалдан авах тендер зарлаагүй, гэрээ байгуулаагүй компани болон хувь хүнээс 17644.2 мянган төгрөгийн материалыг худалдан авсан, өдөрт хэчнээн хэмжээний нүүрс, аргал зарцуулсныг нотлох боломжгүй, 2020 онд нүүрсийг 50 тонн, аргал 19 тонноор буюу 5450.0 мянган төгрөгийг өмнөх оноос илүү зарцуулсан нь байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан дотоод хяналт хэрэгжүүлээгүй, тайлант оны эцэст Мо Эн Ко ХХК-тай тооцоо нийлж үлдэгдлийг санхүүгийн тайланд 299.1 мянган төгрөгийг өглөгт тусгаагүй орхигдуулсныг нягтлан бодогч нь хүлээн зөвшөөрч залруулаагүй, хүүхдийн хоол хүнсэнд 1 хүүхэд зарцуулах нормоос илүү 2182.8 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой нийт 25576.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 6.4.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Засгийн газрын 2019 оны 450 дугаар "хоолны зардлын норматив тогтоох тухай" тогтоолын 1-д "цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр, 24 цагаар ажилладаг, сувиллын болон тусгай цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 3600 (гурван мянган зургаан зуун) төгрөгөөр тооцно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичих

3. Шилэн дансны хуульд заасны дагуу 2019 оны аудитын тайлан дүгнэлт, хагас жилийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, 5 сая төгрөгөөс дээших санхүүжилтийн орлого, төсвийн хэмнэлт хэтрэлтийн шалтгаан тайлбарыг байршуулаагүй зөрчил байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор,"; 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор,"; 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аудитаар материаллаг хэмжээний алдаа зөрчил илэрсэн тул тус байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт, өгч бараа материалын худалдан авалт, түлээ нүүрсний зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Санхүүгийн программ ашиглалттай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Нягтлан бодогч нь санхүүгийн программд холбогдох дансны бичилтийг буруу хийж авлага өглөгийг бэлтгэн нийлүүлэгч бүрээр тооцоог тулган баталгаажуулаагүй шууд хааж тайлагнасан дутагдал илэрлээ.
- 1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлангийн бодит байдалд алдагдах, тайлан буруу илэрхийлэгдэх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтуудыг мөрдөх, холбогдох дансны бичилтийг үнэн зөв илэрхийлэх

Байгууллагаас өгсөн хариу: Хүлээн зөвшөөрсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: 2021	Аудитын нэр:	Мөст сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ХОА-2021/34/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мөст сумын Цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Албан тушаал
1	2	3	4	5	
1	Өмнөх оны нүүрсний үнийн өглөгөөр тусгаагүй тайлант оны зардлаар бүртгэсэн, багш ажилчдаас авах авлага дутуу тусгасан, зарим аж ахуйн нэгж байгууллагад материалын үнэ илүү шилжүүлсэн авлагаар бүртгээгүй орхигдуулсан,	3321.4	Залруулга хийх	Эрхлэгч, нягтлан бодогч	Т.Оюунцэцэг, П.Баянзул
2	Өмнө онд худалдан авч зарцуулаагүй 302.4 кг махнаас Цэцэрлэгийн үйл ажиллагаа явагдаагүйгээс багш ажилчдад худалдсан, өөх ясыг акталсан, санхүүгийн программд хоолны зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1812.6	Залруулга хийх		
3	Эд хариуцагчийн тайланд орлого авсан санхүүгийн программд бараа материалын орлогоор бүртгээгүй	2234.6	Залруулга хийх		

4	Тайлант үеийн үр дүн зөрүүтэй илэрхийлсэн	1653.5	Залруулга хийх		
5	Өмнөх онд тайланд тусгасан авлагыг өмнөх үр дүн данс руу хаасан, тайлант цалингийн урьдчилгаа олгоод суутган аваагүй, авлагаар тусгаагүй зардлаар тайлагнасан, материалын үнэ илүү шилжүүлсэн авлагаар бүртгээгүй орхигдуулсан	7093.4	Төлбөрийн акт		
6	Тайлант онд мах нийлүүлэх, хүнсний материал худалдан авах тендер зарлаагүй, гэрээ байгуулаагүй компани болон хувь хүнээс мах болон хүнсний материалаа худалдан авсан, өдөрт хэчнээн хэмжээний нүүрс, аргал зарцуулсныг нотлох боломжгүй, 2020 онд нүүрсийг 50 тонн, аргал 19 тонноор өмнөх оноос илүү зарцуулсан нь байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан дотоод хяналт хэрэгжүүлээгүй, тайлант оны эцэст Мо Эн Ко ХХК-тай тооцоо нийлж үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан нягтлан бодогч нь хүлээн зөвшөөрөөгүй, хүүхдийн хоол хүнсэнд 1 хүүхэд зарцуулах нормоос илүү зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.	25576.1	Албан шаардлага өгөх	Эрхлэгч , нягтлан бодогч	Т.Оюунцэцэг, П.Баянзул
7	Шилэн дансны мэдээллийг хянахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын мэдээллийг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, сар бүрийн төсвийн хэмнэлт хэтрэлтийн тайлбар болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна.		Албан шаардлага өгөх	Эрхлэгч , нягтлан бодогч	Т.Оюунцэцэг, П.Баянзул
8	Нягтлан бодогч нь санхүүгийн программд холбогдох дансны бичилтийг буруу хийж авлага өглөгийг бэлтгэн нийлүүлэгч бүрээр тооцоог тулган баталгаажуулаагүй шууд хааж тайлагнасан		Зөвлөмж өгөх	Эрхлэгч , нягтлан бодогч	Т.Оюунцэцэг, П.Баянзул
ДҮН		39457.0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР